

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ДҮРЭМ

## ТӨСӨЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Их Сургууль (цаашид “МУИС” гэх)-ийн мэдлэг бүтээх болон түгээх үйл ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй, ил тод, хууль ёсны дагуу хэрэгжүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино. Хуулиар тусгайлан заагаагүй харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.
- 1.2. МУИС нь бие даасан, эрдмийн эрх чөлөө бүхий, хамтын болон өөрийн удирдлагатай, нийтийн өмчид суурилсан, 1942 онд байгуулагдсан хуулийн этгээд мөн.
- 1.3. МУИС-ийн захиргаа Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана. МУИС-ийн хаяг нь “Монгол Улс, Улаанбаатар хот, 210646, Монгол Улсын Их Сургууль (National University of Mongolia), Их сургуулийн гудамж-1”, цахим хуудас нь [www.num.edu.mn](http://www.num.edu.mn) болно.
- 1.4. МУИС тогтоосон журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, өөрийн бэлгэдэл (эмблем, туг)-тэй байна.
- 1.5. МУИС-ийн үйл ажиллагаанд дараах үндсэн зарчмыг баримтална.
  - 1.5.1. Хууль дээдлэх;
  - 1.5.2. Эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;
  - 1.5.3. Бие даасан байдлыг хангах;
  - 1.5.4. Шударга ёсыг сахих;
  - 1.5.5. Хариуцлагатай байх.

### Хоёр. МУИС-ийн үндсэн чиг үүрэг

- 2.1. Суурь болон хэрэглээний судалгаа явуулж, шинэ мэдлэг бүтээх, сургалт, судлагааны эргэлтэд оруулах, инновацийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.2. Шинжлэх ухаан, технологийн ололт, сургалтын нэгдсэн (улсын) стандарт, нийгмийн эрэлтэд тулгуурлан бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхэлж, мэргэжлийн болон иргэний өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, үндэсний мэргэжилтнүүдийг чадавхижуулна.
- 2.3. Нийгэмд эрдэм мэдлэг түгээх, соён гэгээрүүлэх, улс орны хөгжил дэвшилд нөлөөлөхүйц бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардлагатай шинжлэх ухаанч санал зөвлөмж боловсруулж дэвшүүлнэ.

### Гурав. МУИС-ийн бүтэц

- 3.1. МУИС нь үндсэн үйл ажиллагааны чиглэлээр судалгаа, сургалтын нэгж /бүрэлдэхүүн сургууль, харьяаллын сургууль, сургалтын нэгдсэн алба, төгсөлтийн дараах сургууль, тэнхим, профессорын баг, хүрээлэн, төв, лаборатори, ахлах сургууль/-тэй байна.
- 3.2. МУИС-ийн үндсэн үйл ажиллагааны зорилгод нийцсэн сургалт, судалгаа, инновацийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий үйлчилгээний нэгж

/номын сан, хүн эмнэлэг, шүдний эмнэлэг, судалгааны музей, мэдээлэл, технологи дамжуулах төв, гарааны компани, дадлагын бааз, хэвлэх үйлдвэр, оюутны дотуур байр зэрэг/-тэй байна. МУИС-ийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна.

- 3.3. МУИС нь Шинжлэх ухааны сургууль /Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Хүмүүнлэгийн ухааны салбар/; Бизнесийн сургууль; Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль; Хууль зүйн сургууль; Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль гэсэн бүрэлдэхүүн сургуультай байна.
- 3.4. МУИС-ийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний үндсэн чиг үүргийг бүхэлд нь эсвэл заримыг гүйцэтгэдэг харьяаллын Орхон, Завхан сургуультай байна. Харьяаллын сургуулийн эрх зүйн байдал бүрэлдэхүүн сургуультай ижил байна.
- 3.5. Судалгааны тэргүүлэх болон шаардлагатай чиглэлийг хөгжүүлэхийн тулд тодорхой чиглэлээр судалгааны хүрээлэн, төв, байгуулах асуудлыг тусгай журмаар зохицуулна. Журмыг МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, захирал батална.
- 3.6. Улсын төсвийн бус санхүүжилттэй судалгааны хүрээлэн, төв нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.
- 3.7. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүтээлтэй, МУИС-ийн харьяалалгүй судлаач төсвийн бус эх үүсвэрээр судалгааны хүрээлэн, төв, лаборатори байгуулан ажиллуулж болно.

## **Дөрөв. МУИС-ийн удирдлагын ТОГТОЛЦОО**

### **1 дүгээр зүйл. Удирдах зөвлөл**

- 1.1. МУИС хуульд заасны дагуу үүсгэн байгуулагч, багш, эрдэм шинжилгээний ажилтан, төгсөгч, суралцагчийн төлөөлөл бүхий Удирдах зөвлөлтэй байна.
- 1.2. МУИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох багш, эрдэм шинжилгээний ажилтны төлөөллийг нийт багш, эрдэм шинжилгээний ажилтны хурлаас сонгоно.
- 1.3. Суралцагчийн төлөөллийг сургалтын мэдээллийн системээр нийт оюутны саналаар сонгоно.
- 1.4. Удирдах зөвлөл дэх төгсөгчдийн төлөөллийг бүрэлдэхүүн сургуулийн Төгсөгчдийн холбоо болон төгсөгчдийн бусад байгууллагын удирдлагын хурлаас сонгоно.
- 1.5. МУИС-ийн Удирдах зөвлөлийн даргыг томилогдсон гишүүдийн дундаас ил санал хураалтаар, олонхийн саналаар сонгоно.
- 1.6. МУИС-ийн Удирдах зөвлөл нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн даргыг сонгогдсон багш гишүүдийн дундаас олонхийн саналаар сонгоно.
- 1.7. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамтай байна.
- 1.8. Удирдах зөвлөл нь тогтоол, хурлын тэмдэглэлийн хэвлэмэл хуудастай байх бөгөөд МУИС-ийн тэмдгийг хэрэглэнэ.
- 1.9. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг МУИС-ийн тухайн жилийн төсөвт тусган зарцуулна.
- 1.10. МУИС-ийн Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 1.10.1. МУИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрийг хэлэлцэн батлах, өөрчлөх;

- 1.10.2.** Захиргааны саналыг үндэслэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, дүрмийг хэлэлцэн батлах;
- 1.10.3.** Сургуулийн жилийн төсөв, хөрөнгө оруулалтын хуваарийг баталж, гүйцэтгэл, зарцуулалтад хяналт тавих;
- 1.10.4.** Сургалтын болон дотуур байрны төлбөрийн хэмжээг хэлэлцэн батлах;
- 1.10.5.** Сургуулийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 1.10.6.** Удирдах зөвлөлийн жилийн үйл ажиллагааны тайланг үүсгэн байгуулагчид өгөх;
- 1.10.7.** МУИС-ийн санхүүгийн бодлого, стратегийн хэрэгжилт, төсвийн орлогын бүрдэлт, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон тооны дотоод аудиторыг Удирдах зөвлөлөөс томилж ажиллуулна. Шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллагын туслалцаа авч болно.

## **2 дугаар зүйл. Эрдмийн зөвлөл**

- 2.1. МУИС нь эрдэм шинжилгээ, сургалтын ажлын чиглэлийг тогтоож, түүний онол, арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий профессоруудын төлөөллөөс бүрдсэн Эрдмийн зөвлөлтэй байна.
- 2.2. Эрдмийн зөвлөл нь профессорын албан тушаалын зэрэглэлд ажиллаж байгаа үндсэн орон тооны багш нарын төлөөллөөс бүрдэнэ. Эрдмийн зөвлөл 45 гишүүнтэй байна.
- 2.3. МУИС-ийн захирал, дэд захирлууд Эрдмийн зөвлөлийн гишүүн байна.
- 2.4. МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүнийг бүрэлдэхүүн /салбар/ сургуулийн докторын зэрэгтэй багш нарын дийлэнх олонхийн буюу гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаас нууц санал хураалтаар олонхиор сонгоно.
- 2.5. Эрдмийн зөвлөлд сонгох гишүүний тоо нь бүрэлдэхүүн /салбар/ сургууль бүрт тогтмол орон тоо, тухайн бүрэлдэхүүн сургуулийн профессорын албан тушаалын зэрэглэлд ажиллаж байгаа багшийн тоонд нийцүүлэн жишсэн нэмэлт орон тооноос бүрдэнэ.
- 2.6. МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүний сонгуулийг 3 жил тутамд явуулна.
- 2.7. Эрдмийн зөвлөлийн гишүүн нэг хичээлийн жилээс дээш хугацаагаар эзгүй байх эсвэл орон гарсан тохиолдолд тухайн бүрэлдэхүүн сургуулийн сонгуулийн жагсаалтын дараагийн нэр дэвшигч гишүүн болно.
- 2.8. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааг журмаар зохицуулна.
- 2.9. Эрдмийн зөвлөл нь дарга, эрдэмтэн нарийн бичгийн даргатай байна. Эрдмийн зөвлөлийн дарга нь МУИС-ийн захирал байна.
- 2.10. Эрдмийн зөвлөл нь чиг үүргийн дагуу төрөлжсөн хороодтой байж болно.
- 2.11. Эрдмийн зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.11.1.** МУИС-ийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөрийг хэлэлцэж санал дүгнэлтээ захиргаа, Удирдах зөвлөлд хүргүүлэх;
  - 2.11.2.** МУИС-ийн дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн саналаа Удирдах зөвлөлд хүргүүлэх;
  - 2.11.3.** МУИС-ийн судалгаа, сургалттай холбоотой журмуудыг хэлэлцэж, өөрчлөлт оруулах саналаа захиргаанд өгөх;
  - 2.11.4.** МУИС-ийн эрдмийн цол, хүндэтгэл олгох;

**2.11.5.** МУИС-ийн захирлын үйл ажиллагааны талаар саналаа Удирдах зөвлөлд гаргах.

### **3 дугаар зүйл. Хөтөлбөрийн хороо**

- 3.1. МУИС нь хөтөлбөрийн хороотой байх бөгөөд Эрдмийн зөвлөлөөс баталсан МУИС-ийн Хөтөлбөрийн хорооны журмын дагуу үйл ажиллагаа явуулна. МУИС-ийн Хөтөлбөрийн хороо нь Ерөнхий хороо, Ерөнхий суурь хөтөлбөрийн дэд хороо, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо, тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо гэсэн бүтэцтэйгээр ажиллана. Тэнхимийн бүтэцгүй бол тухайн бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо хөтөлбөртэй холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.2. МУИС-ийн Хөтөлбөрийн хороо нь суралцагчдад шаталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд ерөнхий суурь болон үндсэн, хавсрага, хос мэргэжлийн хичээлд тавих шалгуур үзүүлэлт, багц цаг тооцох, шилжүүлэх нөхцлийг тогтоож, дан ба салбар дундын хамтарсан хөтөлбөрийг шинээр эсвэл шинэчлэн боловсруулах, мэргэжлийн экспертиз хийх, бодлого зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргана.
- 3.3. МУИС-ийн Хөтөлбөрийн хороо дараах чиг үүрэгтэй байна.
  - 3.3.1. МУИС-ийн сургалтын хөтөлбөрийг Монгол улсын боловсролын хууль тогтоомж, МУИС-ийн сургалтын нэгдсэн бодлого, шинжлэх ухааны хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж, олон улсын боловсролын стандартад нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх;
  - 3.3.2. Чиг үүргийн дагуу хэлэлцэж буй асуудлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэргэжлийн үнэлгээ хийх, сургалтын үйл ажиллагааны чанар, стандартыг хангах, оюутан суралцагчдын сурах үйл ажиллагааг идэвхжүүлэх;
  - 3.3.3. Хөтөлбөрийн цагийн багтаамж, оюутны сонголт хийх арга зам, хувилбар болон тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт зэрэг зохицуулалтын механизмыг нарийвчлан тогтоох;
  - 3.3.4. Сургалт явуулахад шаардлагатай багшлах боловсон хүчний нөөц, чадавх, ном, сурах бичиг, номын сан, анги танхимын хүртээмж зэргийг судалж, санал боловсруулан шийдвэр гаргах.

### **4 дүгээр зүйл. МУИС-ийн захирал**

- 4.1. Захирал МУИС-ийг төлөөлж, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 4.2. Захирлын албан тушаалд тавих шаардлагыг Боловсролын тухай хуулийн холбогдох заалтын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан ажлын байрны тодорхойлолтоор тогтооно.
- 4.3. Захирал сургуулийн удирдлагыг Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэм, үүсгэн байгуулагчтай байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлнэ.
- 4.4. Захирал үндсэн үйл ажиллагааны чиглэлээр дэд захирлуудыг томилж, уг албан тушаалд тавих шаардлага, ажлын байрны тодорхойлолтыг батална.

- 4.5. Захирал эзгүй байх хугацаандаа албан үүргээ аль нэг дэд захиралд түр орлуулна. Түр орлосон этгээдийн гаргасан шийдвэрийн хариуцлагыг захирал хүлээнэ.
- 4.6. МУИС-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр ажлын алба, хэлтэстэй байна. Эдгээрийн тоо, бүтэц, орон тоог холбогдох асуудал эрхэлсэн дэд захирал, албаны даргын саналыг үндэслэн захирал батална. Алба, хэлтсийн даргыг эрхэлсэн дэд захирлын саналыг үндэслэн Захирал томилно.
- 4.7. Захирлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад зөвлөх, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх Захиргааны зөвлөлийг ажиллуулна. Захиргааны зөвлөлд асуудал эрхэлсэн дэд захирлууд, алба, хэлтсийн дарга, бүрэлдэхүүн сургууль/салбар/-ийн захирал орно.
- 4.8. Захирал дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ.
  - 4.8.1. Дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийн талаарх төрийн бодлогод нийцүүлэн сургуулийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах;
  - 4.8.2. Хууль тогтоомжийн дагуу МУИС-ийн бүтцийн зохион байгуулалтыг тогтоох, өөрчлөх, татан буулгах, тэдгээрийн тайлан сонсож, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;
  - 4.8.3. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн МУИС-д мөрдөх журмуудыг боловсруулах, батлах, мөрдүүлэх;
  - 4.8.4. Багш, ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, биелэлтийг дүгнэх, хөдөлмөрийн гэрээг цуцлах;
  - 4.8.5. Сургуулийг хөгжүүлэх хөрөнгө, хандив, сургуулийн санхүү, хөрөнгийн эх үүсвэр нэмэгдүүлэх;
  - 4.8.6. Суралцагч элсүүлэх, шилжүүлэн суралцуулах, чөлөөлөх, төгсгөх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх.

## **5 дүгээр зүйл. Бүрэлдэхүүн сургуулийн удирдлага**

- 5.1. Бүрэлдэхүүн сургууль /салбар/ Эрдмийн зөвлөлтэй байна.
  - 5.1.1. Бүрэлдэхүүн сургууль /салбар/-ийн Эрдмийн зөвлөл тухайн сургуулийн профессорын албан тушаалын зэрэглэлд ажиллаж байгаа үндсэн орон тооны нийт багшаас бүрдэнэ.
  - 5.1.2. Бүрэлдэхүүн сургууль /салбар/-ийн захирал эрдмийн зөвлөлийн дарга байна.
- 5.2. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөл дараах чиг үүрэгтэй.
  - 5.2.1. Бүрэлдэхүүн сургуулийн сургалт, судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг хэлэлцэн санал дэвшүүлэх;
  - 5.2.2. Бүрэлдэхүүн сургуулийн цол олгох асуудлаар шийдвэр гаргах;
  - 5.2.3. Бүрэлдэхүүн сургуулийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа судалгааны төслийн явц, тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;
  - 5.2.4. Тухайн сургуулийн эрдэмтдийн боловсруулсан эрдэм шинжилгээний төсөл, суурь судалгааны талаар дүгнэлт гаргах;
  - 5.2.5. Багш нарт бүтээлийн чөлөө олгох асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргах;

- 5.2.6. Бүрэлдэхүүн сургууль/салбар/-ийн захирлын үйл ажиллагааны талаар саналаа Захиралд гаргах;
- 5.3. Бүрэлдэхүүн сургууль /салбар/-ийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана.
  - 5.3.1. Бүрэлдэхүүн сургуулийн захирал нь их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, докторын зэрэгтэй байна.
  - 5.3.2. Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг судлан шалгаруулах хороог МУИС-ийн захирлын тушаалаар байгуулж, хорооны дэвшүүлсэн 2-3 хүнээс захирал сонгон томилно.
  - 5.3.3. Захирал эрх, үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад зөвлөх, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй бүрэлдэхүүн сургууль /салбар/-ийн захиргааны зөвлөлийг ажиллуулна.
  - 5.3.4. Бүрэлдэхүүн сургууль /салбар/-ийн захиргааны зөвлөлд салбар хариуцсан дэд захирал, тэнхимийн бүтэцгүй сургуулийн хөтөлбөр хариуцсан дэд захирал, харьяа тэнхимийн эрхлэгч нар орно.
- 5.4. Бүрэлдэхүүн сургууль /салбар/-ийн захирал дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ.
  - 5.4.1. МУИС-ийн нэгдсэн бодлого, стратегийн хүрээнд бүрэлдэхүүн сургуулийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах, мөрдөж ажиллах, хэрэгжилтийг хангах, тайлагнах, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
  - 5.4.2. Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд сургалтын үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, шаталсан сургалтын хөтөлбөрүүдийг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажил, магистрант, докторант нарыг сургалт, судалгааны туслахаар ажиллуулах асуудлыг зохион байгуулах;
  - 5.4.3. Бүрэлдэхүүн сургуулийн судалгааны бодлого боловсруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөрийн тоо, чанарыг сайжруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах чиглэлээр санаачлагатай ажиллаж, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг олон нийтэд сурталчлах, сургалт-судалгааны ажлын нэгдлийг хангах;
  - 5.4.4. МУИС-ийн захирлаас шилжүүлсэн эрхийн хүрээнд бүрэлдэхүүн сургуулийн санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, ил тод мэдээлэх, олон эх үүсвэрт санхүүгийн тогтолцоог бий болгох, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш, ажилтан, суралцагчдын ажиллах, суралцах таатай орчин, хэвийн нөхцлийг хангах;
  - 5.4.5. Ажил олгогчоос шилжүүлсэн эрхийн хүрээнд бүрэлдэхүүн сургуулийн суралцагчтай холбоотой /сургалтын гэрээ байгуулах, жилийн чөлөө олгох, үргэлжлүүлэн суралцуулах/ асуудлыг шийдвэрлэх, багш, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээг цуцлах, чөлөө олгох, үргэлжлүүлэн ажиллуулах саналыг МУИС-ийн захиргаанд уламжлах;
  - 5.4.6. Бүрэлдэхүүн сургуулийг төлөөлж, гадаад, дотоодын их, дээд сургууль, байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулах;
  - 5.4.7. Харьяа нэгж тэнхим, лаборатори, төвийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, удирдлагыг өөрчлөх саналыг МУИС-ийн захиралд мэдүүлэх;

5.4.8. Сургууль нийгмийн харилцаа холбоог хөгжүүлэх, төгсөгчдийг ажлын байраар хангах, мэргэжил дээшлүүлэх, сургуулийг хөгжүүлэхэд төгсөгч дэмжигчдийг татан оролцуулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

## **6 дугаар зүйл. Тэнхим**

- 6.1. Тэнхимийн эрхлэгч нь тухайн салбараар мэргэшсэн, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, докторын зэрэгтэй байна.
- 6.2. Тэнхимийн эрхлэгчийг ажлын байрны шаардлага хангасан иргэдээс тухайн тэнхимийн багш нарын саналыг харгалзан МУИС-ийн захирал томилно.
- 6.3. Тэнхимийн эрхлэгч жил бүр үйл ажиллагааны тайланг тэнхимийн багш нараар хэлэлцүүлнэ.
- 6.4. Тэнхимийн шийдвэр гаргах хэлбэр нь тэнхимийн багш нарын хурал байх бөгөөд багш нарын 2/3-оос доошгүй нь хуралд оролцсоноор ирц бүрдэх ба дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргана.
- 6.5. Тэнхимийн эрхлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
  - 6.5.1. Тэнхимийн судалгаа, сургалтын үйл ажиллагааг үр ашигтай, хариуцлагатай удирдан зохион байгуулах;
  - 6.5.2. Мэргэжил, хөтөлбөрөө сурталчлах, харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх;
  - 6.5.3. Тэнхимийн багш, ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа, ёс зүйн байдалд дүгнэлт өгөх, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох талаар дээд шатны удирдлагад санал оруулах;
  - 6.5.4. Тэнхимийн судалгаа, сургалтын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, дүгнэлт гаргуулах, үр дүнг тэнхимийн хурлаар хэлэлцүүлэх;
  - 6.5.5. Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс тэнхимийн нийт хичээлийн хуваарь, оюутны сонголтонд үндэслэн багш, анги танхимийн хүрэлцээ, сургалтын техник тоног төхөөрөмжийн хангалт, хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
  - 6.5.6. Тэнхимийн харьяалалд байгаа ерөнхий суурь, үндсэн мэргэжил, хавсрага мэргэжил, хос мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, оюутан суралцагчдыг шаардлагатай мэдээллээр хангах, энэ чиглэлийн оюутанд үзүүлэх үйлчилгээг сайжруулах.

## ТАВ. МУИС-ийн БАГШ, АЖИЛТАН, СУРАЛЦАГЧ

- 5.1. МУИС-ийн багш, ажилтан, суралцагч нь яс үндэс, гарал үүсэл, шашин шүтлэг, хүйс, улс төрийн үзэл бодол, гэр бүлийн байдал зэрэг ямар нэгэн ялгаварлал, давуу тал, гадуурхлаас ангид байна. Суралцагч сурлагын дүнгээс бусад эрхийг тэгш эдлэнэ.
- 5.2. Багш, ажилтан, суралцагч нь хууль тогтоомж, энэхүү дүрэм, МУИС-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмууд, МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллана.
- 5.3. Багш, ажилтан нь хууль тогтоомжийн дагуу тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан болон ажлын шаардлагын дагуух бусад ажил үүргийг захирал буюу түүний эрх олгосон этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.
- 5.4. Багш, ажилтны сул орон тоог нээлттэй зарлаж, сонгон шалгаруулж авна.
- 5.5. Багш, ажилтныг 3 жил тутам аттестатчилах бөгөөд аттестатчиллыг тусгай журмаар зохицуулна.
- 5.6. МУИС-ийн багш тухайн салбараар мэргэшсэн, тодорхой чиглэлээр судалгаа явуулдаг, магистр, түүнээс дээш зэрэгтэй байна. Ахисан түвшний сургалтанд оролцох багш докторын зэрэгтэй байна.
- 5.7. Багшийн албан тушаал, мэргэжлийн үнэлэмжийг судалгаа, сургалт, нийгмийн болон инновацийн үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрээр тодорхойлно.
- 3.8. МУИС-ийн харьяа улсын төсөвт эрдэм шинжилгээний хүрээлэн, төв нь чадварлаг судлаачдад нээлттэй байх ба тогтмол орон тооны эрдэм шинжилгээний ажилтан 40 хувиас ихгүй, гэрээт эрдэм шинжилгээний ажилтан 60 хувиас багагүй байна. Тогтмол орон тоон дээр ажиллах эрдэм шинжилгээний ажилтан докторын зэрэгтэй байна.
- 3.9. Магистрант, докторант нарыг гэрээт эрдэм шинжилгээний ажилтан, судалгаа, сургалтын туслахаар ажиллуулахыг дэмжинэ.
- 3.10. Суралцагчийг элсүүлэх, сургах, төгсгөх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон нийтлэг журамд үндэслэн боловсруулж баталсан журмаар зохицуулна.
- 3.11. Суралцагч Монгол Улсын боловсролын хууль болон бусад хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмын дагуу мэдээлэл, үйлчилгээ Монгол сургуулийн удирдах зөвлөлд төлөөлөлтэй байх, сургалтын төлөвлөгөөний хүрээнд хичээл болон багшийг сонгох, амжилттай суралцсаны тэтгэлэг, дэмжлэг авах, сургалттай холбоотой асуудлаар холбогдох байгууллагад санал хүсэлт тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.
- 5.8. Суралцагч сургалтын хөтөлбөрт заасан сургалтын бүх хэлбэрийн үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох, тогтоосон хугацаанд шалгалтыг өгч сургалтын бусад даалгаварыг гүйцэтгэх, багш, ажилтан, бусад суралцагчдад хүндэтгэлтэй хандаж, харилцах үүрэгтэй.



## Зургаа. МУИС-ийн хөрөнгө, санхүү

- 6.1. МУИС-ийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан урт хугацааны зорилго, зорилтын хүрээнд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг тогтвортой, иж бүрэн, үнэн зөв, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн явуулна.
- 6.2. МУИС-ийн төсөв дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
  - 6.2.1. Татаас санхүүжилтийн орлого /Улсын төсөв/;
  - 6.2.2. Сургалтын төлбөр;
  - 6.2.3. Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт болон захиалгат судалгааны ажлын санхүүжилт;
  - 6.2.4. Аж ахуйн үйл ажиллагааны орлого;
  - 6.2.5. Зохих журмын дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, төгсөгчдөөс өгсөн хандив тусламж;
  - 6.2.6. Зээл;
  - 6.2.7. Лицензийн болон патентын төлбөр;
  - 6.2.8. Хадгаламжийн болон харилцах дансны үлдэгдлийн хүү;
  - 6.2.9. Түрээсийн төлбөр;
  - 6.2.10. МУИС-ийн **Endowment** сан;
  - 6.2.11. Хуульд нийцсэн санхүүгийн бусад эх үүсвэр.
- 6.3. МУИС-ийн эдийн засаг, санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг төсвийн шууд захирагч, асуудал эрхэлсэн дэд захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирал, бүртгэл санхүүгийн ажилтнууд хариуцан гүйцэтгэнэ.
- 6.4. Сургуулийн хөрөнгө, санхүүгийн нөөцийг төсвийн дагуу хуваарилж, зарцуулах бөгөөд төсвийн шууд захирагч Удирдах зөвлөлөөс баталсан төсвийг захиран зарцуулна.
- 6.5. Төсвийн шууд захирагч төсвийн зарим хэсгийг захиран зарцуулах эрх мэдлээ гэрээний үндсэн дээр бүрэлдэхүүн сургуулийн захиралд шилжүүлж болно.
- 6.6. МУИС-ийн болон бүрэлдэхүүн сургуулийн төсвийн төсөл, төсөв, төсвийн гүйцэтгэл, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, санхүүгийн тайлан, түүнд хийсэн эдийн засгийн шинжилгээ, аудитын дүгнэлт, тендерийн баримт бичиг, шалгуур үзүүлэлт, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, худалдан авах үйл ажиллагааны тайланг хуульд заасан хугацаанд сургуулийн цахим хуудсанд байрлуулна.